

БАЯНХОНГОР АЙМАГТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ГЭРЭЭ

Энэхүү гэрээг нэг талаас: Баянхонгор аймаг (цаашид "Аймаг" гэх), нөгөө талаас ашигт малтмалын MV-006907, MV-006720 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч "Наран мандал Энтерпрайзес" ХХК (цаашид "Компани" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 дэх хэсгийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Баянхонгор аймаг Баянхонгор суманд байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Баянхонгор аймаг Баян-Овоо сумын Мандалхайрхан 1 дүгээр багийн нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон MV-006907, MV-006720 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Компани нь үйл ажиллагаа явуулж байгаа аймгийн байгаль орчныг хамгаалалтыг сайжруулах, үйлдвэр байгуулах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр энэхүү Гэрээнд зааснаар дэмжлэг үзүүлнэ.

2. Аймгийн эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Аймгийг төлөөлөн Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

AGREEMENT ON INVESTMENT TO BAYANKHONGOR AIMAG

This Agreement is concluded between Bayankhongor aimag (hereinafter referred to as "Aimag") /on the one side/ and "Naran Mandal Enterprises" LLC, License holder of MV-006907 and MV-006720 (hereinafter referred to as "Company") /on the other side/ based on Clause 42.1 of the Minerals Law, the parties (hereinafter referred to as "the Parties") agreed on the following terms on May 31, 2021 in Bayankhongor soum, Bayankhongor aimag.

1. General provisions

1.1. This Agreement shall regulate the cooperation between the Aimag and the Company, holding license No. MV-006907, MV-006720 issued in accordance with the Minerals Law and other relevant laws and regulations in Mandalkhairkhan 1st bagh of Bayan-Ovoo soum, Bayankhongor aimag, on issues related to developing infrastructure in regards to environmental protection, mining, and establishment of factories, and increasing workplaces.

1.2. The Company shall provide support, as stated in this Agreement, to projects and initiatives oriented towards developing infrastructure, increasing employment and improving environmental protection in the aimag in which the Company operates.

2. Rights and Obligations of the Aimag

2.1. Under this Agreement, the Governor shall exercise the following rights and obligations on behalf of the Aimag:

НАРАН
ЭНТЕРПРАЙЗЕС

НАРАН
ЭНТЕРПРАЙЗЕС

11
52958
УЛААНБААТАР
БҮЛГЭЭ

- 2.1.1. Компани Хууль тогтоомж, энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хуулиар олгогдсон эрхийн хүрээнд хяналт тавих;
 - 2.1.2. Энэхүү Гэрээний дагуу 8.4-д зааснаар Компани шууд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрт санал өгөх;
 - 2.1.3. Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ, барааг дэмжих зорилгоор тэдгээрийг Компанид танилцуулах, холбогдох мэдээлэл, танилцуулга, сурталчилгааг Компанид хүргүүлэх;
 - 2.1.4. Хууль, тогтоомжийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр Компанийг хангах;
 - 2.1.5. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар орон нутгийн иргэдэд тогтмол мэдээлэл өгч, саналыг нь авах;
 - 2.1.6. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, хөтөлбөрөөс Компанитай хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөрийг түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр сонгож, энэ тухай иргэдэд мэдээлэх;
 - 2.1.7. Компаниас татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын зарцуулалт, төсөл, тэдгээрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайланг улирал бүрийн
- 2.1.1. Within the scope of its legal rights, to monitor the implementation of obligations of the Company under related Laws and this Agreement,
 - 2.1.2. To suggest project proposals and programs to be directly financed by the Company, as stated in Clause 8.4 of this Agreement;
 - 2.1.3. To provide relevant information, brochures, and advertisements to the Company to introduce local products, services, and goods for support;
 - 2.1.4. To provide the Company with stable and normal working conditions to conduct its mineral exploration, prospecting and mining operations within the framework of laws and regulations;
 - 2.1.5. To provide local citizens with regular information about the projects and initiatives implemented and planned to be implemented under this Agreement and receive their feedback;
 - 2.1.6. To organize meetings and discussions related to the implementation of this Agreement, and select projects and activities that can be jointly implemented with the Company once approved by the Citizens' Representative Khural upon their consultation and will inform the citizens about the above measures;
 - 2.1.7. To report to the Company, in writing at the end of each quarter, on the expenditure of investment donated by the Company and the implementation of projects and plans, and to provide all related

эцэст Компанид бичгээр тайлагнах, мэдээллээр саадгүй хангах;

2.1.8. Тохиролцсон графикт хуваарийн дагуу хөрөнгө оруулалт хийх үүргийн биелэлтийг хангуулах үүднээс хууль, тогтоомжийн хүрээнд Компанийг хэвийн, тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, дэмжлэг, туслалцааг үзүүлэх;

2.1.9. Компанийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх;

2.1.10. Компанийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх;

2.1.11. Компанид сум, аймгийн төрийн байгууллагын албан хаагчид, иргэдээс хууль бус эсхүл хор уршигтай дарамт шахалт үзүүлэх асуудлыг таслан зогсоох, буруутай этгээдэд арга хэмжээ авах, хариуцлага ногдуулах;

2.1.12. Компаниан аймаг орон нутагт үзүүлсэн хандив, дэмжлэг туслалцааг ОНХС-аараа дамжуулан авч, жил бүрийн уул уурхайн зөвлөгөөн дээр тайлагнаж байх;

2.1.13. Компанийн Тусгай зөвшөөрлийн талбайд ажиллаж буй ХАМОДХ, хувиараа ашигт малтмал олборлогч иргэд нь хууль тогтоомж, эрх зүйн акт, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй эсэхэд хяналт тавих, хувиараа

information without hindrance;

2.1.8. To ensure and provide the Company with normal working conditions within the legal frameworks and regulations in order to enable the Company to fulfill its obligation to make investments in accordance to the agreed schedule and provide supports;

2.1.9. To disseminate information related to the vacancies announced by the Company and procurement of goods, labor and services to the public in a transparent and open manner;

2.1.10. To resolve the requests and demands of the Company in accordance with the laws and regulations and provide appropriate responses;

2.1.11. To eliminate illegal or harmful actions of local government officials and citizens of the soum and aimag against the Company and to take measures and impose sanctions on the guilty parties;

2.1.12. Donations and support provided by the Company to the Aimag and locals shall be received to the LDF (local development fund) and shall be reported at annual mining meetings;

2.1.13. To monitor whether the artisanal miners and HAMODH NGO that are operating within the licensed area of the Company are fulfilling their obligations under the laws, regulations and their agreements. The Aimag shall furthermore eliminate any

ашигт малтмал олборлогч иргэдийн зөрчлийг таслан зогсоох, Компанид ХАМОДХ-ны аливаа дарамт шахалт, эсхүл Компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харш бусад этгээдийн санал, шаардлага тулгах зэрэг үйлдлээс ангид байлгаж хамгаалах, буруутай этгээдүүдэд хуулийн хариуцлага тооцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.14. Аливаа хууль бус шаардлага тавих, үндэслэлгүй баримт материал гаргаж өгөхийг шаардах, урдчилан мэдэгдэлгүйгээр аливаа уулзалт, хурал зохион байгуулж, түүнд оролцохыг тулгах, үйл ажиллагааг зогсоох, тасалдуулах зэргээр саад учруулахгүй байх;

2.1.15. Хууль, гэрээнд заагаагүй нэмэлт болон давхардуулан татвар, төлбөр, хураамж, хөрөнгө оруулалт, хандив, тусламж шаардахгүй байх, албан тушаалтнуудын энэ талаарх хууль бус шаардлагыг таслан зогсоох, анхааруулах;

2.1.16. Цар тахал, халдварт өвчний үед Аймаг эсхүл түүний эрх бүхий байгууллагууд нь Компанийн уурхайн үйл ажиллагаанд шалгалт хийхгүй. Хэрвээ шалгалт хийх шаардлагатай Компанийн халдвар хамгааллын бодлого, журмыг баримтална;

2.1.17. Компанийн үйл ажиллагаа, түүний ажилчдыг бодитоор дэмжих, хамгаалах.

3. Компанийн эрх, үүрэг

breach or violation by the artisanal miners to protect the Company from harassment by the NGO and/or actions or demands against its rights and legitimate interests of the Company, and to take legal action against the guilty person;

2.1.14. Shall not obstruct the Company by making any illegal demands and/or demanding documents without reasonable cause, organizing meetings and conference without prior notice, and/or forcing the Company to participate in any such meeting, or suspending or interrupting its activities for any reason thereof;

2.1.15. Not to demand additional and duplicate taxes, fees, charges, investments, donations, or other forms of assistance that are not specified in laws or the Agreement; and to eliminate any such illegal demands from officials;

2.1.16. During a pandemic or the spread of communicable disease, the Aimag or its authorities should not conduct an inspection of the Company's mine site. If it is necessary to conduct an inspection, authorities or officials shall comply with the Company's infection control policies and procedures;

2.1.17. To support and protect the Company's operation and its employees.

3. Rights and responsibilities of the

3.1. Энэхүү гэрээний хүрээнд Компани дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бус эсхүл үндэслэлгүй эсхүл шударга бус байдлаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж Компанид нааштайгаар шийдвэрлүүлэх эрхтэй;

3.1.2. Компанийн орлого буурах, хаагдах, эсхүл бусад санхүүгийн хүндрэл үүссэн нөхцөлд хөрөнгө оруулалт хийх хугацааг энэхүү Гэрээний хугацааны дотор хойшлуулах эрхтэй.

3.1.3. Цар тахал, халдварт өвчний үед Компанийн баримталж буй халдвар хамгааллын бодлого, журмыг дагаагүй Аймаг эсхүл түүний эрх бүхий байгууллагуудын албан тушаалтнуудыг уурхайд нэвтрүүлэхээс татгалзах эрхтэй.

3.1.4. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай боломжоороо хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах, сонгон шалгаруулалтыг өөрсдийн дотоод дүрэм журамд нийцүүлэн явуулах, сул ажлын байранд гагцхүү шаардлага хангасан

Company

3.1. Under this Agreement, the Company shall exercise the following rights and obligations:

3.1.1. The Company shall have the right to inform and demand the Governor and the Citizens' Representatives Khural to settle the matter to the benefit of the Company if any illegal, unreasonable or unfair obstruction is caused by a local citizen or legal entity;

3.1.2. The Company has the right to defer or postpone any investments to the Aimag or soum within the term of this Agreement in the event of a loss of income or closure or any other financial difficulties experienced by the Company;

3.1.3. During a pandemic or the spread of communicable disease, the Company has the right to refuse entry to the mine site to officials from the Aimag or its competent authorities who have not complied with its infection control policies and procedures;

3.1.4. To make a reasonable effort to cooperate with local labor organizations to support the employment and training of local citizens by announcing the vacancies and its criteria in a transparent and open manner to conduct the selection in accordance with its internal rules and regulations, and to hire only those who meet the criteria without external force or influence of others;

этгээдийг бусдын дарамт шахалт, нөлөөлөлгүйгээр сонгож ажиллуулахыг бүхий л боломжоороо хичээх;

3.1.5. Хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулахыг хичээх;

3.1.6. Ажиллах хүчнийхээ 50 хувийг орон нутгаас ажиллуулахыг эрмэлзэх. ХХҮГ-ын мэдээллийн санд бүртгэлтэй иргэдээс ажилд авах, Ажлын байрны зарыг ХХҮГ-аар дамжуулан зарлах, тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулахыг хичээнэ;

3.1.7. Гадаад орноос мэргэжилтэн, ажилтан урт хугацаагаар авч ажиллуулахад холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Гадаадын иргэн, харьяатын газарт бүртгүүлэх;

3.1.8. Хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар тухайн аймгийн иргэдэд улирал бүр мэдээлэл өгч байна. Компани эсхүл хамааралтай хувь хүний нууцтай холбогдох мэдээ, мэдээлэл, баримт бичгийг танилцуулах, гаргаж өгөх, мэдээллээр хангах үүрэг хүлээхгүй;

3.1.9. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй, холбогдох хууль тогтоомж болон Компаниас тавьсан шаардлагад нийцсэн татвар төлөгч иргэн,

3.1.5. To strive to develop the necessary on-the-job training program within the framework of projects and activities to be implemented, and organize activities to involve local people;

3.1.6. To strive to locally employ 50 percent of the workforce, by recruiting from citizens registered in the database of the Labor and Welfare Service Agency upon advertising vacancies through Labor and Welfare Service Agency, and employ local people on the basis of the appropriate level of training;

3.1.7. To register any international employee or professional that shall be working for long-term to the Immigration Office in accordance with the relevant laws;

3.1.8. To provide quarterly information to the citizens of the Aimag about the projects and activities being implemented. The Company shall not be obliged to present, submit or otherwise provide any confidential information related to the Company or its associated individuals;

3.1.9. When purchasing goods, labor and services or selecting a member of the labor force, the Company will endeavor to give priority to taxpayers and legal entities who are registered in the Aimag and those who meet the

хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгох, орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн нь чанар, хэмжээ, цаг хугацаа болно бусад стандартын шаардлага хангасан нөхцөлд бараа бүтээгдэхүүнийг бусад зах зээлээс авахгүй байхыг тус тус эрмэлзэх;

3.1.10. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг биелүүлж ажиллах;

3.1.11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэх

3.1.12. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр өөрийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлд тухайн орон нутагт боломжит техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

3.1.13. Гурван талууд бүгд зөвшөөрсөн, мөн Компани, түүний санхүү, үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхээргүй тохиолдолд зохион байгуулалтад орсон бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гурвалсан гэрээний үндсэн дээр Компанийн эдийн засгийн үр ашиггүй гэж үзсэн Тусгай зөвшөөрлийн тодорхой хэсэгт ажиллуулах;

requirements of the relevant legislation of the Company. The Company shall strive not to purchase products from other markets if the locally produced goods meet the requirements of quality, quantity, timeliness and other standards;

3.1.10. To comply with the environmental protection plan, programs, environmental impact assessment and mining plans respectively reviewed and approved by the ministry in charge of nature and environment, and the relevant organization;

3.1.11. To complete technical and biological rehabilitation as outlined in the annual environmental protection plan

3.1.12. To provide, within reason, equipment and machinery, manpower and other materials, provided that such assistance would not impede its own operations, to the community on a voluntary basis during the event of a disaster;

3.1.13. To allow artisanal and small-scale mining communities to work on designated sub-portions of the licensed area that the Company deems to be non-economic, upon the assurance that it won't harm the Company or its financial position or operations upon the mutual agreement of all three parties based on the tripartite agreement;

- 3.1.14. Эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах.
- 3.1.15. Хэрвээ боломжтой, үндэслэл бүхий бөгөөд Компанийн боломжид нийцэж байвал Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд аймаг сум орон нутгийн өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санал санаачилга гаргах
- 3.1.16. Мах, сүү, хүнсний ногоог тухайн орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан худалдан авахыг хичээх
- 3.1.17. Ажлын хувцас, дээжний уут, эм ханган нийлүүлэх, харуул хамгаалалтыг сонгохдоо Компаниас тавьсан чанарын болон стандартын шаардлагыг бүрэн хангасан, тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийг сонгохыг хичээх. Хэрвээ тухайн орон нутгийн нийлүүлэгчид нь Компаниас тавьсан шаардлага, стандартад нийцээгүй бол Компани тэднийг сонгох үүрэг хүлээхгүй;
- 3.1.18. Олборлосон металлыг Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лаборатори эсхүл бусад баталгаажсан лабораториор баталгаажуулахыг эрмэлзэх бөгөөд, Монгол банк эсхүл эрх бүхий арилжааны банкинд тушааж байх;
- 3.1.19. Ус ашигласны төлбөрийг тоолуураар
- 3.1.14. To comply with the legal requirements set by the competent authority.
- 3.1.15. Within the framework of its social responsibility, take the initiative to provide support for the solution of any issues facing the Aimag, soum and local community if it is reasonable, possible and in accordance with the Company's abilities;
- 3.1.16. Strive to purchase meat, milk and vegetables under contract with a local citizen or business entity;
- 3.1.17. Strive to select local taxpayers and legal entities that fully meet the quality and standard requirements set by the Company when selecting suppliers of work clothes, sample bags, medicines, and security guards. The Company is not obliged to select local suppliers if they cannot meet the standards or requirements set by its management;
- 3.1.18. Strive to have mined metal certified by the Precious Metals Sampling Laboratory of Western region or another authorized laboratory and always sell to the Bank of Mongolia or an authorized commercial bank;
- 3.1.19. Water usage fees shall be paid by the meter as

хуульд заасны дагуу
төлнө.;

- 3.1.20. Техник хяналтын зардал болох 1,000,000 /нэг сая/ төгрөгийг Баянхонгор аймгийн төрийн сангийн "БХ-техник хяналтын зардал - 100030051304" тоот дансанд гэрээ байгуулсны дараа байршуулна;

4. Гэрээний хэрэгжилт

- 4.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

- 4.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

- 4.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

5. Гэрээний хариуцлага

- 5.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

- 5.2. Компани гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

- 5.3. Хөрөнгө оруулалтыг зориулалт

specified by the law.

- 3.1.20. The cost of 1,000,000 / one million / tugrugs for technical inspection shall be deposited in the "BH-technical inspection cost - account 100030051304" of the state treasury fund of Bayankhongor aimag after concluding the Agreement.

4. Implementation of the Agreement

- 4.1. The Parties shall inform the local people after establishing the agreement to ensure its transparency and the Agreement and its related documents shall be posted on the Parties' websites within 3 working days. A copy of the Agreement shall be submitted to the Sub-Council of the Extractive Industries Transparency Initiative of the Aimag within 5 working days.

- 4.2. The parties shall annually evaluate the implementation of the Agreement and submit the report to the Aimag and Citizens' Representatives Khural by February 1st of the following year.

- 4.3. The parties shall submit the annual report on the implementation of the Agreement to the State administrative body in charge of geology and mining by February 15th of the following year.

5. Liability

- 5.1. If the parties fail to fulfill their obligations under the Agreement, they shall bear liabilities stipulated in the relevant law and legislation.

- 5.2. The Company shall submit a report on whether the Agreement has been concluded to the state administrative body in charge of geology and mining within the specified period.

- 5.3. The Company shall have the right

бусаар үр ашиггүй зарцуулсан, хуваарилалт хийхдээ хувьдаа завшсан, төсөл, хөтөлбөрийг сонгохдоо хувийн ашиг сонирхлоор хандсан, нэгдмэл сонирхолтой этгээдүүдэд олгосон тохиолдолд хөрөнгө оруулалтыг буцаан татах, Аймгаас нөхөн гаргуулах, дараагийн хөрөнгө оруулалт хийхээс татгалзах эрхийг Компани эдэлнэ.

5.4. Гэрээний хугацаанд Компанийн үйл ажиллагааг ямар нэг хэлбэр, шалтгаанаар зогсоосон бол оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөн төлүүлэх, дараагийн хөрөнгө оруулалт хийхээс татгалзах эрхийг Компани эдэлнэ.

6. Маргаан шийдвэрлэх

6.1. Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ

6.2. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо Сингапурын Олон Улсын Арбитарт тус Арбитрын дүрмийн дагуу гаргаж болно. Аливаа маргаан нь Гурван арбитарчаар шийдвэрлэгдэнэ.

7. Гэрээ хүчин төгөлдөр болох

7.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш дөрвөн жилийн хугацаанд хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

7.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй

to withdraw the investments, demand reimbursement from the Aimag and to refuse to make subsequent investments if any funding has been inefficiently disbursed for other purposes, or misused for personal interest, or given to affiliated persons for personal benefit.

5.4. If the Company's activity is stopped or terminated in any way for any reason during the term of the Agreement, the Company shall have the right to refuse to make further investments and to be reimbursed the previous investments made during the term of this Agreement.

6. Resolving disputes

6.1. The Parties shall use their best efforts to settle amicably all disputes arising out of or in connection with the implementation or the interpretation of the Agreement.

6.2. The parties shall seek to settle disputes and conflicts related to the implementation of the Agreement amicably, and in case of failure to reach an agreement, may file a complaint to Singapore International Arbitration Centre in accordance with the rules of the Center. Three arbitrators shall settle a dispute.

7. Agreement enforcement

7.1. The Agreement shall be valid for four years from the date of signing by the Parties.

7.2. The Agreement may be terminated prior to its expiration date due to force majeure.

7.3. The Agreement may be amended by mutual agreement of the Parties. Amendments to the Agreement shall be valid as the Agreement and shall be an integral part of the Agreement.

хэсэг болно.

7.4. Гэрээг Монгол, Англи хэл дээр 3 хувь үйлдэнэ. Англи болон Монгол хэл дээрх хувиуд адил хүчин чадалтай байна.

8. Төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах

8.1. Талууд тухайн аймгийн иргэдийн санал хүсэлтэд суурилсан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан орон нутгийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны /2020–2025 он/ төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас сонгон орон нутгийг урт хугацаанд хөгжүүлэх төсөл хөтөлбөрийг хамтран боловсруулж Гэрээний энэ зүйлд зааснаар санхүүжүүлж хэрэгжилтийг хамтран ажиллах гэрээнд тусган ажиллана.

8.2. Компани нь Гэрээний хүчин төгөлдөр байх 4 жилийн хугацаанд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд нөлөөлөх нөлөөллийг бууруулах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зэрэг тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор сайн дурын үндсэн дээр дараах тусламжийг шууд болон ОНХСангаар дамжуулан үзүүлнэ. Үүнд:

№	Дансны эзэмшигч Account holder	Дансны дугаар Account number	Дүн /төгрөг/ Amount /tugrug/	Хугацаа Term
1	Баянхонгор-BHR ОНХСан Bayankhongor – BHR Local development fund	100030052400	1,250,000,000	1 дэх жил 1 st year
2			1,000,000,000	2 дахь жил 2 nd year
3			1,000,000,000	3 дахь жил 3 rd year
4			1,000,000,000	4 дэх жил 4 th year

8.3. Компани Гэрээний 8.2-д заасан эхний жилийн хөрөнгө оруулалт дээр Компани өөрийн санхүүгийн нөөц, боломжоосоо

7.4. The Agreement shall be made in 3 copies in Mongolian and English. English and Mongolian shall have an equal effect.

8. Project and program development, implementation and reporting

8.1. The parties shall jointly develop long-term local development projects and programs selected from the long and medium-term (2020-2025) development plans approved by the Citizens' Representatives Khural of the Aimag that are based on local citizens' requests, and shall fund the projects and programs in accordance with this Article of the Agreement and shall reflect their implementation in the cooperation agreement.

8.2. During the 4 years of the Agreement, the Company shall provide the following investments directly and through the local development fund on a voluntary basis in order to support local development, such as reducing impacts on the environment and population, developing infrastructure and increasing employment.

8.3. In addition to the investment for the first year specified in Clause 8.2 of the Agreement, the Company will make reasonable effort to invest up

хамааруулан нэмж 750,000,000 хүртэлх төгрөгийн хөрөнгө оруулалтыг энэхүү Гэрээний 8.4-д зааснаар шууд хөрөнгө оруулалтаар оруулахаар ажиллана. Хэрвээ Компани тус хөрөнгө оруулалтыг эхний жилд оруулж чадаагүй бол Гэрээний 3.1.2-д зааснаар дараагийн жилүүдэд оруулахыг эрмэлзэнэ.

- 8.4. Компани Гэрээний 8.2-д заасан хөрөнгө оруулалтаас тодорхой хувийг Аймгийн засаг даргатай зөвшилцсөний дагуу шууд санхүүжилт хийх, гүйцэтгэгч шалгаруулах, шууд удирдах эсхүл хэрэгжүүлэх замаар хэрэгжүүлж болно.
- 8.5. Гэрээний 8.2-д заасан хөрөнгө оруулалтаас гучин хувийг Баян-Овоо сум руу энэхүү Гэрээ болон Гэрээний 8.6-д заасан хуваарьт нийцүүлэн шилжүүлнэ.
- 8.6. Талууд энэхүү Гэрээний 8.2-д заасан жил бүрийн хөрөнгө оруулалт хийх хуваарийг тухайн жил бүрийн нэг дүгээр улиралд багтаан харилцан тохирч гаргана.
- 8.7. Хэрвээ Аймгийн засаг даргаас албан бичгээр 8.2-д зааснаас өөр данс руу хөрөнгө оруулалтыг шилжүүлэх хүсэлт ирүүлсэн тохиолдолд Компани тухайн албан бичигт дурьдсан данс руу шилжүүлнэ.
- 8.8. Компани өөрийн санаачлагаар 8.2 болон 8.3-т заасан хөрөнгө оруулалтаас гадна Нийгмийн хариуцлагын хүрээнд сайн дурын үндсэн дээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж болно.
- 8.9. Компани нь Цагдаагийн албаны тухай хуулийн 94.1-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь нийтийн хэв журам хамгаалах чиг

to MNT 750,000,000, depending on its financial resources and capabilities, as direct investment as specified in Clause 8.4 of this Agreement. If the Company fails to make the investment in the first year, it will strive to make the investment in subsequent years in accordance with Clause 3.1.2 of the Agreement.

- 8.4. The Company can implement a certain percentage of the investment specified in clause 8.2 of the Agreement through direct financing, by selection of the contractor or direct management or implementation in accordance with a mutual agreement with the Governor of the Aimag.
- 8.5. Thirty percent of the investment specified in clause 8.2 of the Agreement shall be transferred to Bayan-Ovoo soum in accordance with this Agreement and the schedule stated in Clause 8.6 of the Agreement.
- 8.6. Within the first quarter of each year, the Parties shall discuss and prepare an annual investment schedule in accordance with the schedule stated in Clause 8.2 of this Agreement.
- 8.7. If the Governor requests, in writing, to transfer the investment to an account other than the account specified in Clause 8.2, the Company shall transfer the investment to the account specified in the written request letter.
- 8.8. The Company may implement projects and programs within the framework of its social responsibility on its own initiative on a voluntary basis in addition to the investments specified in 8.2 and 8.3.
- 8.9. As stated in the Clause 94.1 of the Law on the Police "The Citizens' Representatives Khural and the Governor are required to provide housing, food, transportation and

үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно” гэж заасны дагуу ОНХСанд Компанийн оруулж буй хөрөнгө оруулалтаас аймгийн Засаг дарга санхүүжүүлэхийг дэмжиж ажиллана.

communication facilities to the police officers in charge of the territory, in order to create conditions for the implementation of public order functions, and expenditures required to support the appointed officers and their families can be financed from the local budget”, the Company shall support the financing by the Governor of the Aimag from the investment donated by Company to the local development fund.

ГЭРЭЭГ ХЯНАСАН/ REVIEWED BY:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА
Д.САРАНГАРАВ

HEAD OF LEGAL DEPARTMENT OF
BAYANKHONGOR AIMAG
GOVERNOR'S OFFICE
D. SARANGARAV

“НАРАН МАНДАЛ ЭНТЕРПРАЙЗЕС”
ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨХ:
Б.ЗААНТОГТОХ

GENERAL COUNSEL OF “NARAN
MANDAL ENTERPRISES” LLC:
B.ZAANTOGTOKH

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН / AGREEMENT IS CONCLUDED BY AND BETWEEN:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА:
Д.МӨНХСАЙХАН

THE GOVERNOR OF
BAYANKHONGOR AIMAG:
D.MUNKHSAIKHAN

“НАРАН МАНДАЛ ЭНТЕРПРАЙЗЕС”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:
МАЙКЛ ФИШЕР

EXECUTIVE DIRECTOR OF
“NARAN MANDAL ENTERPRISES” LLC:
MICHAEL FISCHER